



2017 оны 07 дугаар сарын 05
№25 /982/

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

**Монгол Улсын
хууль**

**Монгол Улсын нэгдсэн төсвийн
2018 оны төсвийн хүрээний
мэдэгдэл, 2019-2020 оны
төсвийн төсөөллийн тухай**

**Монгол Улсын
Их Хурлын
тогтоол**

**“Монгол Улсын эдийн засаг,
нийгмийг 2018 онд хөгжүүлэх
үндсэн чиглэл” батлах тухай**

**Монгол Улсын
Ерөнхийлөгчийн
зарлиг**

**Зарим хүмүүсийг анхан шатны
шүүхийн шүүгчийн албан
тушаалд шилжүүлэн
томилох тухай**

ГАРЧИГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

436. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2018 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2019-2020 оны төсвийн төсөөллийн тухай 1681

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

437. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2018 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2019-2020 оны төсвийн төсөөллийн тухай хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай Дугаар 41 1683
438. Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэл батлах тухай Дугаар 42 1684

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

439. Зарим хүмүүсийг шүүхийн шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай Дугаар 82 1721
440. Зарим шүүхийн шүүгч, Ерөнхий шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай Дугаар 83 1721
441. Зарим хүмүүсийг анхан шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд шилжүүлэн томилох тухай Дугаар 84 1722
442. Элчин сайдыг эгүүлэн татах, тохоон томилох тухай Дугаар 88 1723
443. Элчин сайдыг эгүүлэн татах, тохоон томилох тухай Дугаар 89 1723
444. Элчин сайдыг эгүүлэн татах, тохоон томилох тухай Дугаар 90 1724

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2017 оны 05 дугаар сарын 31-ний өдөр

Улаанбаатар хот

МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН 2018 ОНЫ ТӨСВИЙН ХҮРЭЭНИЙ МЭДЭГДЭЛ, 2019-2020 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨӨЛЛИЙН ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2018 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2019-2020 оны төсвийн төсөөллийн үзүүлэлтийг доор дурдсанаар баталсугай:



Эдийн засгийн үндсэн үзүүлэлт		Төсвийн хүрээний мэдэгдэл	Төсвийн төсөөлөл	
		2018 он	2019 он	2020 он
1	Дотоодын нийт бүтээгдэхүүний бодит өсөлтийн хэмжээ /хувь/	1.8	8.1	5.3
2	Хэрэглээний үнийн өсөлтийн түвшин	6.1	6.9	6.5
3	Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын хэмжээ /тэрбум төгрөг/	6,808.4	7,803.1	8,759.2
	-Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	24.6	24.9	25.0
4	Нэгдсэн төсвийн нийт зарлагын дээд хэмжээ /тэрбум төгрөг/	9,451.0	9,971.0	10,555.0
	-Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	34.1	31.8	30.1
5	Нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлтийн хэмжээ /тэрбум төгрөг/	700.8	520.0	584.0
	-Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	2.5	1.7	1.7
6	Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл /тэрбум төгрөг/	-2,642.6	-2,167.9	-1,795.8
	-Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	-9.5	-6.9	-5.1
7	Нэгдсэн төсвийн хөрөнгийн зардлын хэмжээ /тэрбум төгрөг/	1,623.0	1,875.0	2,262.0
	-Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	5.9	6.0	6.5



8	Засгийн газрын өрийн нийт хэмжээ /өнөөгийн үнэ цэнээр, тэрбум төгрөг/	22,155.2	23,547.0	24,516.1
	-Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	80.0	75.0	70.0
9	Нийгмийн халамжийн тухай хуульд заасны дагуу төсвөөс санхүүжүүлэх зардлын нийт хэмжээ /тэрбум төгрөг/	499.6	531.0	565.5
	-Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	1.8	1.7	1.6

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА**

Ц.НЯМДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2017 оны 05 дугаар
сарын 31-ний өдөр

Дугаар 41

Улаанбаатар
хот

**Монгол Улсын нэгдсэн төсвийн 2018 оны
төсвийн хүрээний мэдэгдэл, 2019-2020 оны
төсвийн төсөөллийн тухай хууль баталсантай
холбогдуулан авах арга хэмжээний тухай**

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Улсын Их Хурлын 2016 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн 71 дүгээр тогтоолоор баталсан “Эдийн засгийг сэргээх хөтөлбөр” болон Олон Улсын Валютын Сангийн “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-ийн хүрээнд хэрэгжүүлсэн эдийн засаг, санхүү, төсвийн бодлогын арга хэмжээний хүрээнд эдийн засгийн нөхцөл байдал сайжирч, төсвийн орлого нэмэгдэх тохиолдолд Монгол Улсын нэгдсэн төсвийн 2018 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2019-2020 оны төсвийн төсөөллийн тухай хуулиар батлагдсан эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийг Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хуулийн төслийг боловсруулах үед дахин авч үзэж, холбогдох өөрчлөлтийг дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд тусгах арга хэмжээ авахыг Монгол Улсын Засгийн газар /Ж.Эрдэнэбат/-т даалгасгай.



2.Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороо /Ч.Хүрэлбаатар/-нд даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА**

Ц.НЯМДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2017 оны 05 дугаар
сарын 31-ний өдөр

Дугаар 42

Улаанбаатар
хот

“Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэл” батлах тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.“Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”-ийг хавсралтаар баталсугай.

2.“Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолыг “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”, Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын 2018 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2019-2020 оны төсвийн төсөөллийн тухай хууль, бодлогын бусад баримт бичиг, хөтөлбөртэй уялдуулан хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Ж.Эрдэнэбат/, Монголбанк /Н.Баяртсайхан/, Санхүүгийн зохицуулах хороо /С.Даваасүрэн/ болон холбогдох бусад байгууллагад үүрэг болгосугай.

3.“Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”-ийг баталсантай холбогдуулан хэрэгжилтийг оны эхнээс жигд ханган зохион байгуулж, биелэлтийг бүтэн жилээр гаргаж, Улсын Их Хуралд танилцуулахыг Монгол Улсын Засгийн газар /Ж.Эрдэнэбат/-т даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА**

Ц.НЯМДОРЖ

Монгол Улсын Их Хурлын 2017 оны
42 дугаар тогтоолын хавсралт

МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2018 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛ

Д/д	Урт болон дунд хугацааны хөтөлбөр, бодлогын баримт бичиг	Зорилт, арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	2018 онд хүрэх түвшин, үр дүн	2018 онд шаардлагатай хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр /гэрбум төгрөг/	Хариуцах байгууллага
1	2	3	4	5	6	7
НЭГ. МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО						
Зорилт 1. Макро эдийн засгийн суурь нөхцөлийг сайжруулах замаар эдийн засаг, санхүүгийн тогтвортой байдлыг хангах бодлого хэрэгжүүлнэ.						
1.1	Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал -2030 /цаашид "МУТХҮБ-2030" гэх/-ын 2.1, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр /цаашид "ЗГУАХ" гэх/-ийн 1.1, Эдийн засгийг сэргээх хөтөлбөр /цаашид "ЭЭСХ" гэх/-ийн 2.2 дахь заалт	Макро эдийн засгийн тэнцвэрт байдлыг хангах замаар эдийн засгийн өсөлтийг бий болгох	Дотоодын нийт бүтээгдэхүүн /цаашид "ДНБ" гэх/-ий бодит өсөлт, хувиар	1.8	-	Засгийн газар
1.2	МУТХҮБ-2030-ын 2.2.1, Зорилт 2, ЗГУАХ-ийн 3.3.6 дахь заалт, ЭЭСХ-ийн 2.3.10 дахь заалт	Ажлын байрыг нэмэгдүүлэх, ажилгүйдлийн түвшинг бууруулах	Ажилгүйдлийн түвшин, хувиар	8.0-аас ихгүй	-	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам /цаашид "ХНХЯ" гэх/



1.3	МУТХҮБ-2030-ын 2.1, ЭЗСХ-ийн 1.2 дахь заалт	Инфляцийг тогтвортой, нам түвшинд байлгах мөнгөний бодлого хэрэгжүүлэх	Инфляцийн түвшин, оны эцэст хувиар	6.1	-	Монголбанк, Засгийн газар
1.4	МУТХҮБ-2030-ын 2.1.6, Зорилт 1, ЗГҮАХ-ийн 1.4, ЭЗСХ-ийн 1.1 дэх заалт	Дунд хугацаанд төсвийн үндсэн тэнцлийг эерэг болгох нөхцөлийг бүрдүүлж, нэгдсэн төсвийн тэнцлийн алдагдлыг өмнөх оны түвшнээс бууруулах	Нэгдсэн төсвийн алдагдлын ДНБ-д эзлэх хэмжээ, хувиар	9.5	-	Сангийн яам /цаашид "СЯ" гэх/
1.5	МУТХҮБ-2030-ын 2.1, ЗГҮАХ-ийн 1.22, 5.6, ЭЗСХ-ийн 1.3.5 дахь заалт	Эдийн засгийн суурь үзүүлэлтүүд болон Монгол Улсын эзэлжих зэрэглэлийг сайжруулж, гадаадын хөрөнгө оруулагчдын итгэлийг сэргээж, хөрөнгө оруулалт татах арга хэмжээг авч хэрэгжүүлэх	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100	1.2 Улсын төсөв	СЯ, Үндэсний хөгжлийн газар /цаашид "ҮХГ" гэх/
1.6	МУТХҮБ-2030-ын 2.1 дэх заалт	Валют болон мөнгөний захын дэд бүтцийг боловсронгуй болгох арга хэмжээ авах	Банк хоорондын арилжааны эргэлт нэмэгдэх, хувиар /өмнөх гурван жилийн дунджаас/	15.0	-	Монголбанк, СЯ, Санхүүгийн зохицуулах хороо /цаашид "СЗХ" гэх/
1.7	МУТХҮБ-2030-ын 2.1 дэх заалт	Банк, санхүүгийн салбарыг хямралд хүргэж болзошгүй эрсдэлийг нарийвчлан тодорхойлох	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100	-	Монголбанк, СЗХ

1.8	МУТХҮБ-2030-ын 2.2.1, зорилт 1, ЗГУАХ-ийн 1.16 дахь заалт	Банкны системийн зээлийн эрсдэлд сөрөг нөлөө үзүүлэхгүйгээр иргэдийн санхүүгийн үйлчилгээг тэгш хүртэх эрх ашгийг хамгаалах арга хэмжээг авах	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100	-	Монголбанк
1.9	МУТХҮБ-2030-ын 2.1.7, ЗГУАХ-ийн 2.48 дахь заалт	Үйлдвэрлэлийг хөгжүүлэх, бизнесийн таатай орчинг бүрдүүлэх, жижиг зээлийн хүртээмжийг нэмэгдүүлэх бодлого хэрэгжүүлэх	Шинээр бий болгох ажлын байрны тоо, мянга	45.0	-	ХНХЯ
1.10	МУТХҮБ-2030-ын 2.1.7, ЗГУАХ-ийн 3.3.24 дэх заалт	Бизнес эрхлэлтийн санхүүгийн зардлыг бууруулах бодлого хэрэгжүүлэх	Мөнгөний захыг хөгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт, хувиар	10.0-иас багагүй	-	Монголбанк, СЗХ
1.11	МУТХҮБ-2030-ын 2.1.6, зорилт 2, ЗГУАХ-ийн 2.6 дахь заалт	Хөрөнгийн зах зээлийн хүртээмжийг нэмэгдүүлж, олон нийтийн оролцоог хангах эрх зүйн орчинг боловсронгуй болгох	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100.0	-	СЗХ, Монголбанк, СЯ
1.12	МУТХҮБ-2030-ын 2.1.6, зорилт 3, ЗГУАХ-ийн 1.8 дахь заалт	Засгийн газрын гадаад зээлийн үйлчилгээний төлбөрийг бууруулах хөтөлбөр боловсруулах	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100.0	-	СЯ
1.13	МУТХҮБ-2030-ын 2.1.6, зорилт 1, ЗГУАХ-ийн 1.4 дэх заалт	“Үндэсний хэмнэлтийн хөтөлбөр” боловсруулж, хэрэгжүүлэх	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100.0	-	СЯ

ХОЁР ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТИЙГ ДЭМЖИХ САЛБАРУУДЫН БОДЛОГО

Зорилт 2. Хөдөө аж ахуйн салбарын хөгжлийг эрчимжүүлж, бүтээгдэхүүний чанар, ашиг шимийг нэмэгдүүлнэ.

2.1	МУТХУБ-2030-ын 2.1.1, Зорилт 1, ЗГҮАХ-ийн 2.32 дахь заалт	Малын халдварт, гоц халдварт болон архаг халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, мал сүргийг эрүүлжүүлэх	Вақинжуулалтад хамрагдах малын тоо, сая толгой /давхардсан тоогоор/	50-аас багагүй	20.0 Улсын төсөв	Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам /цаашид "ХХААХҮЯ" ГЗХ/
2.2	МУТХУБ-2030-ын 2.1.1, Зорилт 1, ЗГҮАХ-ийн 2.33 дахь заалт	Бэлчээрийн монгол малын ашиг шимийг нэмэгдүүлэх зорилгоор үүлдэр, омог, хэвшлийн цөм сүргийн малаар сайжруулах, өндөр ашиг шимт цэвэр үүлдрийн малын тоог нэмэгдүүлэх	Шинээр нэмэгдүүлэх үржлийн цөм сүргийн өсвөр хээлтүүлэгч малын тоо	1000	0.3 Улсын төсөв	ХХААХҮЯ
				50-аас багагүй	2.0 Улсын төсөв	
2.3	МУТХУБ-2030-ын 2.1.1, Зорилт 1, ЗГҮАХ-ийн 2.36, 2.38 дахь заалт	Бэлчээрийн ашиглалт, хамгаалалтыг сайжруулах зорилгоор отрын бүс нутаг, нөөц бэлчээрийг нэмэгдүүлэх	Отрын бүс нутгийн судалгаанд хамрагдах талбайн хэмжээ, га	35.0	0.05 Улсын төсөв	ХХААХҮЯ

2.4	МУТХҮБ-2030-ЫН 2.1.1, Зорилт 3, ЗГҮАХ-ийн 2.39- 2.47, ЭЗСХ-ийн 2.1.8 дахь заалт	Атрын III аяныг үргэлжлүүлэн хэрэгжүүлж, техник, тоног төхөөрөмжийн шинэчлэл хийх	Аяны хэрэгжилт, хувиар	30.0	ХХААХҮЯ, Аймаг, нийслэлийн Засаг Даргын Тамгын газар /цаашид "АНЭДТТ" гэх/	
			Зоорийн багтаамжийн нэмэгдэх хэмжээ, тн	7000		20.0 Улсын төсөв
			Усалгаатай талбайг нэмэгдүүлэх хэмжээ, га	3000		
2.5	МУТХҮБ-2030-ЫН 2.1.1, Зорилт 4, ЗГҮАХ-ийн 2.44, ЭЗСХ-ийн 2.1.13 дахь заалт	Өвөл, зуны хүлэмжийн аж ахуй байгуулж, хот суурин газрын хүн амыг шинэ ургацын хүнсний ногоогоор хангах	Тоног төхөөрөмжийн шинэчлэлийн хувь	75.0	ХХААХҮЯ, АНЭДТТ	
			Шинээр нэмэгдэх хүлэмжийн талбайн хэмжээ, га	10		6.0 Гадаад эх үүсвэр
Зорилт 3. Хөнгөн, хүнсний салбар, жижиг, дунд үйлдвэрлэлийг бодлогоор дэмжинэ.						
3.1	МУТХҮБ-2030-ЫН 2.1.1, Зорилт 2, ЗГҮАХ-ийн 2.20, 2.41, 2.47, 2.48 дахь заалт	Хөдөө аж ахуйн салбарын эрх зүйн орчинг боловсронгүй болгох	Шинээр болон шинэчлэн боловсруулах эрх зүйн баримт бичгийн тоо	5	ХХААХҮЯ	
			Хөдөө аж ахуйн салбарын эрх зүйн орчинг боловсронгүй болгох	-		
3.2	МУТХҮБ-2030-ЫН 2.1.3, Зорилт 2, ЗГҮАХ-ийн 2.18, 2.23, 2.34 дэх заалт	"Эрүүл хүнс-Эрүүл Монгол хүн" үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх, "Мах, сүүний анхдугаар аян"-ыг зохион байгуулж, хүн амыг эрүүл, аюулгүй хүнсний бүтээгдэхүүнээр хангах	Хөтөлбөрийн хэрэгжилт, хувиар	40.0	ХХААХҮЯ	
				30.0 Улсын төсөв		



3.3	МУТХҮБ-2030-ын 2.1.3, Зорилт 1, 4, ЗГҮАХ-ийн 2.48 дахь заалт	Үндэсний үйлдвэрлэлийг хөгжүүлэх “Үйлдвэржилт 21-100 үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх	Хөтөлбөрийн хэрэгжилт, хувиар	20.0	100.0 Гадаад эх үүсвэр	ХХААХҮЯ
3.4	МУТХҮБ-2030-ын 2.1.1, Зорилт 4, ЗГҮАХ-ийн 2.15, ЭЗСХ-ийн 1.2.4 дэх заалт	Жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийг эзэлийн бодлогоор дэмжих	Санхүүжүүлэх төслийн тоо	400	20.0 Улсын төсөв	ХХААХҮЯ, СЯ
3.5	МУТХҮБ-2030-ын 2.1.1, Зорилт 4, ЗГҮАХ-ийн 2.15, ЭЗСХ-ийн 1.2.4 дэх заалт	Жижиг, дунд үйлдвэр, хувиараа бизнес эрхлэгчдийг дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлэх	Хөтөлбөрийн хэрэгжилт, хувиар	30.0	100.0	ХХААХҮЯ
3.6	ЗГҮАХ-ийн 2.51 дэх заалт	“Монгол ноолуур” хөтөлбөрийг хэрэгжүүлэх	Хөтөлбөрийн хэрэгжилт, хувиар	40.0	-	ХХААХҮЯ
3.7	МУТХҮБ-2030-ын 2.1.3, Зорилт 1, 4, ЗГҮАХ-ийн 2.58, ЭЗСХ-ийн 1.1.6 дахь заалт	Төрөөс худалдан авах дотоодын үйлдвэрийн бүтээгдэхүүний нэр төрөл, тоо хэмжээг нэмэгдүүлэх	Худалдан авалтын өсөлтийн хувь	10.0	-	ХХААХҮЯ, Төрийн өмчийн бодлого, зохицуулагын газар “ТӨБЗГ” ГЗХ
			Нэмэгдүүлэх нэр төрлийн тоо	10	-	
3.8	МУТХҮБ-2030-ын 2.1.3, Зорилт 2, ЗГҮАХ-ийн 1.23 дахь заалт	Үндэсний үйлдвэрлэлийг дэмжих худалдан авалтын бодлогыг батлан хамгаалах, хил хамгаалах, онцгой байдал, цагдаагийн болон бусад төрийн байгууллагад тууштай хэрэгжүүлэх эрх зүйн орчинг бүрдүүлэх	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100.0	-	ТӨБЗГ

Зорилт 4. Геологи, уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарыг хөгжүүлж, бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлнэ.

4.1	МУТХУБ-2030-ын 2.1.4, Зорилт 1, ЗГҮАХ-ийн 2.59-2.61, Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого /цаашид ТЭБСББ/-ын 3.2.2 дахь заалт	Геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлыг үргэлжлүүлэх	Хамруулах газар нутгийн хэмжээ, хувиар /1:50000 масштаб/	42.0	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам /цаашид "УУХУЯ" гэх/
			Улсын геологийн иж бүрдэл зургийг К болон L хавтгайн хэмжээнд нэгтгэх ажлыг хамруулах газар нутгийн хэмжээ, хувиар	25.0	
			Агаарын геофизикийн судалгааны ажилд хамрагдах газар нутгийн хэмжээ, хувиар	15.0	
			Геохимийн зураг зохиох ажилд хамрагдах газар нутгийн хэмжээ, хувиар /1:1000000-ын масштаб/	20.0	
			Томоохон хотуудын геоэкологич, гидрогеологийн судалгаа болон сэдэвчилсэн судалгааны ажлын тоо	6	

4.2	МУТХҮБ-2030-ын 2.1.3, Зорилт 3, ЗГҮАХ-ийн 2.69, ЭЭСХ-ийн 1.3.1 дэх заалт	“Алт-2” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд Монгол орны алтны хэтийн төлөвийг тогтоох	Хамруулах газар нутгийн хэмжээ, хувиар	30.0	1.8 Улсын төсөв	УУХҮЯ
			Оюу толгойн далд уурхайн бүтээн байгуулалтын ажлын явц, хувиар	45.0	2600.0 Хувийн хөрөнгө оруулалт	
4.3	МУТХҮБ-2030-ын 2.1.4, Зорилт 2, ЗГҮАХ-ийн 1.24, ЭЭСХ-ийн 2.2.1 дэх заалт	Уул уурхайн салбарын томоохон төсөл хөтөлбөрүүдийн үйл ажиллагааг эрчимжүүлэх	Тавантолгойн орд ашиглах болон хөрөнгө оруулалтын гэрээний дагуу хэрэгжүүлэх ажлын явц, хувиар	20.0	380.0 Хувийн хөрөнгө оруулалт	УУХҮЯ
4.4	МУТХҮБ-2030-ын 2.1.3, Зорилт 3, 4, ЗГҮАХ-ийн 2.70-2.73, ЭЭСХ-ийн 1.3.8 дахь заалт	Хүнд аж үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх	Гацууртын төслийг хэрэгжүүлэх ажлын явц, хувиар	20.0	150.0 Хувийн хөрөнгө оруулалт	
			Газрын тос боловсруулах үйлдвэр болон түүхий тос дамжуулах хоолойн барилгын ажлыг эхлэх бэлтгэлийг хангах, хувиар	10.0	131.0 Гадаад эх үүсвэр	

			Зэсийн баяжмал хайлуулах, цэвэршүүлэх үйлдвэрийн ТЭЗҮ, нарийвчилсан зураг төсөл боловсруулах ажлын явц, хувиар	100	2.5 Хувийн хөрөнгө оруулалт	УУХҮЯ, ҮХГ
			“Уул уурхай, металургийн цогцлоор” төслийн 2 дугаар шатны бүтээн байгуулалтын ажлын явц, хувиар	20.0	200.0 ТХХТ	
			Нүүрс угаах, гүн боловсруулах үйлдвэрийн барилгын ажлын явц, хувиар	10.0	607.5 Хувийн хөрөнгө оруулалт	
4.5	МУТХҮБ-2030-ын 2.1.3, зорилт 3, ЗГҮАХ-ийн 2.71 дэх заалт	Эрдэнэт хотод зэсийн баяжмал хайлуулах үйлдвэр барих	Бэлтгэл ажлын явц, хувиар	100.0	-	УУХҮЯ, ҮХГ
Зорилт 5. Эрчим хүчний хэрэглээг дотоодын эх үүсвэрээр хангах бодлого хэрэгжүүлж, хүчин чадлыг нэмэгдүүлнэ.						
5.1	МУТХҮБ-2030-ын 2.1.5, Зорилт 1, ЗГҮАХ-ийн 2.97, ЭЗСХ-ийн 2.2.1, 2.2.3 дахь заалт	Эрчим хүчний салбарын тасралтгүй, найдвартай ажиллагааг хангах зорилгоор ашиглалтад байгаа цахилгаан станцуудыг өргөтгөн шинэчилж, хүчин чадлыг нэмэгдүүлэх	Дарханы ДЦС-ын хүчин чадлыг 35 МВт-аар өргөтгөх ажлын явц, хувиар	100	9.0 Гадаад эх үүсвэр	



			Эрдэнэтийн ДЦС-ын хүчин чадлыг 35 МВт-аар өргөтгөх ажлын явц, хувиар	100	52.0 Гадаад эх үүсвэр	Эрчим хүчний яам /цаашид "ЭХЯ" гэх/
			Чойбалсангийн ДЦС-ын хүчин чадлыг 50 МВт-аар өргөтгөх ажлын явц, хувиар	20.0	50.0 Хувийн хөрөнгө оруулалт	
			ДЦС 3-ын хүчин чадлыг 250 МВт-аар өргөтгөх ажлын явц, хувиар	10.0	70.0 Хувийн хөрөнгө оруулалт	
5.2	МУТХҮБ-2030-ын 2.1.5, Зорилт 1, ЗГҮАХ-ийн 2.98, ЭЭСХ-ийн 2.2.1 дэх заалт	Өмнийн говийн цахилгаан эрчим хүчний хэрэглээг дотоодын эх үүсвэрээр хангах ажлыг эрчимжүүлэх	Тавантолгойн 450 МВт-ын цахилгаан станцын барилгын ажлын явц, хувиар	20.0	190.0 Хувийн хөрөнгө оруулалт	ЭХЯ
5.3	МУТХҮБ-2030-ын 2.1.5, Зорилт 2, ЗГҮАХ-ийн 2.100, ЭЭСХ-ийн 2.2.3 дахь заалт	Сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрүүдийн барилгын ажлыг үргэлжлүүлэх	Эрдэнэбүрэнгийн 64 МВт-ын УЦС-ын барилгын ажлын явц, хувиар	10.0	10.0 Хувийн хөрөнгө оруулалт	ЭХЯ
			Эгийн голын 315 МВт-ын УЦС, дэд бүтцийн барилгын ажлын явц, хувиар	10.0	20.0 Хувийн хөрөнгө оруулалт	
			Баруун бүсийн 20 МВт-ын НЦС-ын барилгын ажлын явц, хувиар	10.0	5.0 Гадаад эх үүсвэр	

			Сайншандын 52 МВТ-ын ЦЦС-ын барилгын ажлын явц, хувиар	100	50.0 Хувийн хөрөнгө оруулалт	
5.4	МУТХҮБ-2030-ын 2.1.5, Зорилт 1, ЗГУАХ-ийн 2.101, ЭЗСХ-ийн 2.2.3 дахь заалт	Бүс нутгийн эрчим хүчний эх үүсвэрүүдийг холбосон цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцыг барьж, эрчим хүчний нэгдсэн систем байгуулах ажлыг үргэлжлүүлэх	Улаанбаатар-Мандалговийн 330 кВ-ын 2 хэлхээт ЦДАШ, дэд станцын барилга угсралтын ажлын явц, хувиар Багануур-Өндөрхаан-Чойбалсангийн 2 хэлхээт 220 кВ-ын ЦДАШ, дэд станцыг барих санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлэх ажлын явц, хувиар	100	90.0 Гадаад эх үүсвэр -	ЭХЯ
5.5	МУТХҮБ-2030-ын 2.1.5, Зорилт 1, ЗГУАХ-ийн 2.102 дахь заалт	Аймгийн төвүүдэд байгаль орчинд ээлтэй дулааны станц, шугам сүлжээ барих ажлыг үргэлжлүүлэх	Шинээр ашиглалтад оруулах станцын тоо	3	41.0 Гадаад эх үүсвэр	ЭХЯ
5.6	МУТХҮБ-2030-ын 2.1.5, Зорилт 1, ЗГУАХ-ийн 2.102, 2.103 дахь заалт	Хот, суурин газрын цахилгаан түгээх сүлжээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх	Цахилгаан эх үүсвэрээр хангах өрхийн тоо	4000-аас багагүй	6.0 Улсын төсөв	ЭХЯ
5.7	МУТХҮБ-2030-ын 2.1.5, Зорилт 1, ЗГУАХ-ийн 2.97 дахь заалт	Багануурын ДЦС-ыг барих ажлыг үргэлжлүүлэх	Барилгын ажлын явц, хувиар	10.0	-	ЭХЯ

Зорилт 6. Бодит салбарын өсөлтийг дэмжих, зам, тээврийн бодлого хэрэгжүүлж, логистикийн сүлжээг өргөжүүлнэ.

6.1	МУТХҮБ-2030-ын 2.1.5, Зорилт 4, ЗГҮАХ-ийн 2.118, 5.1.3 дахь заалт	Зам, тээврийн салбарын эрх зүйн орчинг боловсронгуй болгох	Шинээр болон шинэчлэн боловсруулах эрх зүйн баримт бичгийн тоо	3	Зам, тээврийн хөгжлийн яам /цаашид "ЗТХЯ" гэх/
6.2	МУТХҮБ-2030-ын 2.1.5, Зорилт 3-4, ЗГҮАХ-ийн 2.107, 2.121 дэх заалт	Олон Улс, хот хоорондын болон орон нутгийн авто замыг хатуу хучилттай болгох ажлыг үргэлжлүүлэх, авто замын ашиглалтын хэвийн нөхцөлийг хангах	Ашиглалтад орох хатуу хучилттай авто замын урт, км	486.1	ЗТХЯ
6.3	МУТХҮБ-2030-ын 2.1.5, Зорилт 3-4, ЗГҮАХ-ийн 2.119 дэх заалт	Улаанбаатар хотын авто замын нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлэх	Авто зам засвар, арчлалт хийгдэх ажлын явц, хувиар	100	ЗТХЯ
6.4	МУТХҮБ-2030-ын 2.1.5, Зорилт 3-4, ЗГҮАХ-ийн 2.108-2.112, ЭЗСХ-ийн 2.2.2 дахь заалт	Бодит салбарын хөгжлийг дэмжих төмөр замын төслүүдийг үргэлжлүүлэх	Баянзүрх болон Сонголонгийн гүүрийн барилгын ажлын явц, хувиар	30.0	ЗТХЯ Нийслэлийн Засаг даргын Тамгын газар /цаашид "НЗДТГ" гэх/
6.4	МУТХҮБ-2030-ын 2.1.5, Зорилт 3-4, ЗГҮАХ-ийн 2.108-2.112, ЭЗСХ-ийн 2.2.2 дахь заалт	Бодит салбарын хөгжлийг дэмжих төмөр замын төслүүдийг үргэлжлүүлэх	Тавантолгой-Гашуун сухайт чиглэлийн төмөр замын барилгын ажлын явц, хувиар	20.0	ЗТХЯ Нийслэлийн Засаг даргын Тамгын газар /цаашид "НЗДТГ" гэх/
6.4	МУТХҮБ-2030-ын 2.1.5, Зорилт 3-4, ЗГҮАХ-ийн 2.108-2.112, ЭЗСХ-ийн 2.2.2 дахь заалт	Бодит салбарын хөгжлийг дэмжих төмөр замын төслүүдийг үргэлжлүүлэх	Хөөт-Бичигт чиглэлийн төмөр замын барилгын ажлын явц, хувиар	70.0	ЗТХЯ Нийслэлийн Засаг даргын Тамгын газар /цаашид "НЗДТГ" гэх/
6.4	МУТХҮБ-2030-ын 2.1.5, Зорилт 3-4, ЗГҮАХ-ийн 2.108-2.112, ЭЗСХ-ийн 2.2.2 дахь заалт	Бодит салбарын хөгжлийг дэмжих төмөр замын төслүүдийг үргэлжлүүлэх	Хөөт-Бичигт чиглэлийн төмөр замын барилгын ажлын явц, хувиар	20.0	ЗТХЯ Нийслэлийн Засаг даргын Тамгын газар /цаашид "НЗДТГ" гэх/

		Нарийнсухайт-Шивээхүрэн чиглэлийн төмөр замын барилгын ажлын явц, хувиар	100	331.7 Хувийн хөрөнгө оруулалт, Гадаад эх үүсвэр	ЗТХЯ, ҮХГ
				229.5 Хувийн хөрөнгө оруулалт, Гадаад эх үүсвэр	
		Зүүнбаян-Ханги чиглэлийн төмөр замын барилгын ажлын явц, хувиар	10.0	225.7 Гадаад эх үүсвэр	
				282.0 ТХХТ	
		“Богдхан” төмөр замын барилгын ажлын явц, хувиар	20.0	65.1 Гадаад эх үүсвэр	ЗТХЯ
				23.3 Гадаад эх үүсвэр	
6.5	МУТХҮБ-2030-ын 2.1.5, Зорилт 3-4, ЗГҮАХ-ийн 2.113 дахь заалт	Худалдааг хөнгөвчлөх тээвэр, логистикийн төв байгуулах ажлыг үргэлжлүүлэх	30.0	23.3 Гадаад эх үүсвэр	
		Хөшигийн хөндийн тээвэр, логистикийн төв байгуулах ажлын явц, хувиар	30.0	65.1 Гадаад эх үүсвэр	ЗТХЯ
		Замын-Үүдийн тээвэр логистикийн төв байгуулах ажлын явц, хувиар	95.0	23.3 Гадаад эх үүсвэр	



6.6	МУТХҮБ-2030-ын 2.1.5, Зорилт 4, ЗГҮАХ-ийн 2.114 дэх заалт	Иргэний нисэхийн салбарын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх	Ховд, Дорнод, Өмнөговь аймгийн нисэх буудлыг өргөтгөх ТЭЗУ, зураг төслийг боловсруулах ажлын явц, хувиар Хэнтий аймгийн нисэх буудлыг өргөтгөн шинэчлэх барилгын ажлын явц хувиар	100.0 30.0	40.3 Гадаад эх үүсвэр	ЗТХЯ
6.7	ЗГҮАХ-ийн 2.107 дахь заалт	Говь-Алтай-Баянхонгор-Улаанбаатарын баруун чиглэлийн хатуу хучилттай авто замын "Хүйтний хөндий" дэх засварын ажлыг гүйцэтгэх	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100.0	-	ЗТХЯ
ГУРАВ. БҮС НУТАГ, ХӨДӨӨГИЙН ХӨГЖИЛ, БАЙГАЛЬ ОРЧНЫ БОДЛОГО						
Зорилт 7. Иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг хангасан хот, суурин газрыг төлөвлөж, импортыг орлох барилгын материалын үйлдвэрлэлийг дэмжинэ.						
7.1	МУТХҮБ-2030-ын 2.1.5, Зорилт 5, 6, ЗГҮАХ-ийн 2.77, 5.2.11, 2.89 дэх заалт	Хүн амын орон сууц, нийтийн аж ахуйн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор салбарын эрх зүйн орчинг боловсронгуй болгох	Шинээр болон шинэчлэн боловсруулах эрх зүйн баримт бичгийн тоо	4	-	Барилга, хот байгуулалтын яам /цаашид "БХБЯ" гэх/
7.2	МУТХҮБ-2030-ын 2.1.5, Зорилт 5-6, ЗГҮАХ-ийн 2.79 дэх заалт	"Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл"-ийг боловсруулах	Төсөл боловсруулах ажлын явц, хувиар	100	2.0 Гадаад эх үүсвэр	БХБЯ

7.3	МУТХҮБ-2030-ын 2.1.5, Зорилт 5-6, ЗГҮАХ-ийн 2.91 дэх заалт	Улаанбаатар хот болон аймгийн төвүүдийн цэвэрлэх байгууламжийг шинэчлэх ажлыг үргэлжлүүлэх	4 аймгийн цэвэрлэх байгууламжийн барилга угсралтын ажлын явц, хувиар Улаанбаатар хотын цэвэрлэх байгууламжийн барилгын ажлын явц, хувиар	70.0	36.6 Гадаад эх үүсвэр	БХБЯ
				100		
7.4	МУТХҮБ-2030-ын 2.1.5, Зорилт 6, ЗГҮАХ-ийн 2.87, ЭЗСХ-ийн 2.1.6, 2.87 дахь заалт	Импортыг орлох барилгын материалын үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлэх	Барилгын гангийн үйлдвэрийн барилгын ажлын явц, хувиар Тусгаарлах дулаан тусгаарлах материалын үйлдвэрийн барилгын ажлын явц, хувиар	100	-	БХБЯ
				50-аас багагүй	9.7 Хувийн хөрөнгө оруулалт	
				10.0	8.0 Гадаад эх үүсвэр	
			Баруун бүсийн цементийн үйлдвэрийн барилгын ажлын явц, хувиар	30.0	19.3 Гадаад эх үүсвэр	

7.5	МУТХҮБ-2030-ын 2.1.5, Зорилт 6, ЗГҮАХ-ийн 2.85 дахь заалт	Гэр хорооллын дахин төлөвлөлийн төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд инженерийн дэд бүтцийн ажлыг эрчимжүүлэх	Инженерийн дэд бүтцийн барилгын ажлын явц, хувиар	30.0	250.0 Гадаад эх үүсвэр	БХБЯ
7.6	ЗГҮАХ-ийн 2.76 дахь заалт	Ипотекийн зээлийн хүртээмжийг нэмэгдүүлэх	Зээлд хамрагдах иргэдийн тоо	6000	360.0 Улсын төсөв	БХБЯ
Зорилт 8. Байгаль орчин, аялал жуулчлалын салбарыг хөгжүүлж, агаар, орчны бохирдлыг бууруулах бодлого хэрэгжүүлнэ.						
8.1	МУТХҮБ-2030-ын 2.1.2, Зорилт 1, ЗГҮАХ-ийн 4.2.8, 4.4.1 дэх заалт	Байгаль орчин, аялал жуулчлалын салбарын эрх зүйн орчинг боловсронгуй болгох	Шинээр болон шинэчлэн боловсруулах эрх зүйн баримт бичгийн тоо	3	-	Байгаль орчин, аялал жуулчлалын яам /цаашид "БОАЖЯ" гэх/
8.2	МУТХҮБ-2030-ын 2.3.3, Зорилт 2, ЗГҮАХ-ийн 4.1.6, 4.1.3.4, 4.1.6 дахь заалт	Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах	Хөтөлбөрийн хэрэгжилт, хувиар	20-оос доошгүй	20.0 Улсын төсөв	БОАЖЯ, БХБЯ, ЗТХЯ, ЭХЯ, НЭДТГ,
			Шинээр болон шинэчлэн боловсруулах стандартын тоо	3-аас багагүй	-	БОАЖЯ
			Аюултай хог хаягдлыг устгах байгууламжийн ТЭЗҮ боловсруулах ажлын явц, хувиар	100	0.1 Гадаад эх үүсвэр	БОАЖЯ

			Цахилгааны урамшуулал болон хөнгөлөлттэй үнээр сайжруулсан зуух, боловсруулсан тулш авах өрхийн тоо	40 000-аас багагүй	4.9 Улсын төсөв	БОАЖЯ, ЭХЯ, НЭДТГ
			Метан хийн хангамжийн мастер төлөвлөгөөний санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлэх явц, хувиар	100	-	ЭХЯ
8.3	МУТХҮБ-2030-ЫН 2.3.1, Зорилт 1, 2.3.3, Зорилт 1, ЗГҮАХ-ийн 4.2.1 дэх заалт	Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг өргөжүүлж, хамгаалалтыг сайжруулах	Тусгай хамгаалалтад авах газар нутгийн хэмжээ мян.га	600-аас багагүй	0.05 Улсын төсөв	БОАЖЯ
8.4	МУТХҮБ-2030-ЫН 2.3.1, Зорилт 1, 2, ЗГҮАХ-ийн 4.2.3, 4.2.4, 4.2.5 дахь заалт	Гидрогеологийн дунд масштабын зураглал хийх, хайгуул судалгааны ажлыг хийж хүн амын унд ахуйн ус хангамжийн эх үүсвэрийг тогтоох, бороо, цасны усыг хуримтлуулах хөв цөөрөм байгуулах, гол, горхи, булаг шандны эхийг хашиж хамгаалах	Шинээр хийх гидрогеологийн зураглалын тоо /1:200000 масштаб/	1	0.2 Гадаад эх үүсвэр	БОАЖЯ, АНЗДТГ
			Хүн амын ахуйн усан хангамжийн эх үүсвэрийг тогтоох хайгуул, судалгааны ажлын тоо	1.0	0.2 Улсын төсөв	
			Шинээр байгуулах хөв, цөөрмийн тоо	3-аас багагүй	0.6 Орон нутгийн төсөв	
			Хамгаалалт хийх булаг шандны тоо	100-аас багагүй		



			Ойжуулалт, нөхөн сэргээлт хийх талбайн хэмжээ, га	5000-аас багагүй		
			Хөнөөлт шавьж, өвчний тархалттай тэмцэх талбайн хэмжээ, мян.га	150-аас багагүй		
8.5	МУТХҮБ-2030-ын 2.3.3, Зорилт 1, ЗГУАХ-ийн 4.2.7 дахь заалт	Ой хамгаалах, нөхөн сэргээх, ойжуулах ажлыг чанаржуулж, хүлэмжийн хийг шингээх чадварыг нэмэгдүүлэх	Ойн цэвэрлэгээ хийх талбайн хэмжээ, мян.га Ой, усан сан бүхий газрын хамгаалалтын дэглэмийг мөрдүүлж, Туул, Сэлбэ, Улиастай голын урсацыг нэмэгдүүлэх үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	30.0	5.8 Улсын төсөв	БОАЖЯ
8.6	ЗГУАХ-ийн 2.36 дахь заалт	Цөлжилтийг сааруулах, газрын доройтлыг бууруулах хүрээнд "Цөлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөр", "Ногоон хэрэм", "Ногоон хөгжлийн бодлого" баримт бичгийн хэрэгжилтийг эрчимжүүлэх	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100.0	-	БОАЖЯ
8.7	МУТХҮБ-2030-ын 2.1.2, Зорилт 1, ЗГУАХ-ийн 4.4.1, ЭЗСХ-ийн 2.1.3 дахь заалт	Аялал жуулчлалын салбарын дэд бүтэц, үйлчилгээний чанарыг сайжруулах	Цогцолбор төв байгуулах ажлын явц, хувиар	45.0	4.0 Хувийн хөрөнгө оруулалт	БОАЖЯ

8.8	МУТХҮБ-2030-ын 2.1.2, Зорилт 1, ЗГҮАХ-ийн 4.4.3 дахь заалт	Аялал жуулчлалын бүс нутагт түүхэн болон төрөлжсөн аялал жуулчлалын төв цогцолбор байгуулах	Улаанбаатар болон Хэнтий аймагт баригдах аялал жуулчлалын цогцолбор төвийн ТЗЗУ, зураг төсөл боловсруулах ажлын явц, хувиар Аялал жуулчлалын цогцолбор төвийн барилгын ажлын явц, хувиар	100.0	15.0 Улсын төсөв, Гадаад эх үүсвэр, Хувийн хөрөнгө оруулалт	БОАЖЯ
Зорилт 9. Гамшгаас хамгаалах мэргэжлийн байгууллагын чадавхыг бэхжүүлж, гамшгийн үеийн бэлэн байдлын түвшинг дээшлүүлнэ.						
9.1	МУТХҮБ-2030-ын 2.3.2, Зорилт 1, ЗГҮАХ-ийн 4.3.3, Гамшгаас хамгаалах талаар төрөөс баримтлах бодлого, хөтөлбөрийг 2012-2020 он хүртэл хэрэгжүүлэх төлөвлөгөө /цаашид ГХТБХХТ гэх/ ий 5.10 дахь заалт	Гамшгаас урьдчилан сэргийлэх, гамшгийн хор уршгийг арилгах, аврах, гал унтраах ангийн чадавхыг сайжруулах	Шинээр баригдах гал унтраах ангийн барилгын тоо	3	2.3 Улсын төсөв	Онцгой байдлын ерөнхий газар /цаашид "ОБЕГ" гэх/

9.2	МУТХҮБ-2030-ын 2.3.2, Зорилт 1, ЗГҮАХ-ийн 4.3.3, ГХТБХХТ-ний 1.12, 5.10 дахь заалт	Онцгой байдлын албаны аврах, гал унтраах техник, тоног төхөөрөмжийг сайжруулах төсөл хэрэгжүүлж, гал түймрийн шалтгааныг шуурхай тодорхойлох галын лабораторийн чадавхыг бэхжүүлэх	Шинээр хэрэгжүүлэх теслийн тоо	2-оос багагүй	10.0 Гадаад эх үүсвэр	ОБЕГ
			Техник, тоног төхөөрөмжийг сайжруулах ажлын явц, хувиар	100		
9.3	МУТХҮБ-2030-ын 2.3.2, Зорилт 1, ЗГҮАХ-ийн 4.3.3 дахь заалт	Гамшгийн эрсдэлийг бууруулах Азийн сайд нарын II бага хурлыг Монгол Улсад зохион байгуулах	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100.0	-	ОБЕГ
9.4	МУТХҮБ-2030-ын 2.3.2, Зорилт 1, ЗГҮАХ-ийн 4.3.3 дахь заалт	Малчдад учрах эрсдэлийг бууруулах зорилгоор цаг агаарын гэнэтийн аюулаас урьдчилан сэргэмжлүүлэх мэдээллийн сүлжээ байгуулах	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100.0	-	ОБЕГ
ДӨРӨВ. ХҮНИЙ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ НИЙГМИЙН БОДЛОГО						
Зорилт 10. Боловсролын үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлж, ая тухтай сурч, боловсрох орчинг бүрдүүлэх бодлого хэрэгжүүлнэ.						
10.1	МУТХҮБ-2030-ын 2.2.3, Зорилт 1, ЗГҮАХ-ийн 3.2.2 дахь заалт	Сургуулийн өмнөх боловсролын хамран сургалтыг нэмэгдүүлэх	Хамран сургалтын бохир жин, хувиар	82.0	12.3 Гадаад эх үүсвэр	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам "БСШУСЯ" гэх/

10.2	МУТХҮБ-2030-ын 2.2.3, Зорилт 2, ЗГҮАХ-ийн 3.2.3, 3.2.6 дахь заалт	Ерөнхий боловсролын сургууль, дотуур байрны хүртээмжийг нэмэгдүүлж, хүүхдийн ая тухтай сурч, боловсрох орчин, нөхцөлийг бүрдүүлэх	Гурван ээлжээр хичээллэж буй сургуулийн тоог бууруулах хувь	17.0	13.6 Гадаад эх үүсвэр	БСШУСЯ
				10	1.0 Гадаад эх үүсвэр	
10.3	МУТХҮБ-2030-ын 2.2.3, Зорилт 2, ЗГҮАХ-ийн 3.2.10 дахь заалт	Ерөнхий боловсролын сургуулийн сурах бичгийн хүртээмжийг нэмэгдүүлэх	Нөхөн хангалтаар хэвлүүлэх сурах бичгийн төрөл	122	1.6 Улсын төсөв	БСШУСЯ
				700	0.15 Гадаад эх үүсвэр	
10.4	МУТХҮБ-2030-ын 2.2.3, Зорилт 4, ЗГҮАХ-ийн 3.2.18 дахь заалт	Дээд боловсролын байгууллагын хүний нөөцийн чадавхыг нэмэгдүүлж, сургалтын хөтөлбөрийг олон улсын жишигт нийцүүлэх	Мэргэжил дээшлүүлэх багшийн тоо	5	0.15 Улсын төсөв	БСШУСЯ
				100.0	10.0 Улсын төсөв	
10.5	МУТХҮБ-2030-ын 2.2.3, Зорилт 1-3, ЗГҮАХ-ийн 3.2.3 дахь заалт	Боловсролын салбарын тоног төхөөрөмжийг шинэчлэн сайжруулах	Төлөвлөгдсөн тоног төхөөрөмжийн хангалт, хувиар	100.0	10.0 Улсын төсөв	БСШУСЯ
10.6	МУТХҮБ-2030-ын 2.2.3, Зорилт 1, ЗГҮАХ-ийн 3.2.2 дахь заалт	Хүүхэд бүрийг цэцэрлэгт хамруулах зорилгоор 2018 оноос тодорхой мөнгө хуваарилах, Гурван ээлжээр хичээллэж буй Ерөнхий боловсролын сургуулийн тоог бууруулахад шаардагдах хөрөнгийн асуудлыг судалгаанд үндэслэн үе шаттай шийдвэрлэх	Хөрөнгийн асуудлыг шийдвэрлэх ажлын явц, хувиар	100.0	-	БСШУСЯ



10.7	ЗГУАХ-ийн 3.2.20 дахь заалт	"Боловсролын зээлийн сан"-гийн хүртээмжийг нэмэгдүүлэх	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100.0	-	БСШУСЯ
10.8	МУТХУБ-2030-ын 2.1.3, зорилт 2, ЗГУАХ-ийн 3.2.8 дахь заалт	Сурагчдыг эх хэлээрээ алдаагүй, зөв бичих, ярих, илтгэх, сэтгэх хэрэглээний бүрэн чадвартай болгох хэрэгцээнд нийцүүлэн монгол хэлний сургалтын цогц шинэчлэлийг хэрэгжүүлэх	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100.0	-	БСШУСЯ
10.9	МУТХУБ-2030-ын 2.2.1, зорилт 2, ЗГУАХ-ийн 3.3.10 дахь заалт	Цэцэрлэгийн туслах болон асрагч багш нарыг мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвөөр бэлтгэх	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100.0	-	БСШУСЯ
10.10	МУТХУБ-2030-ын 2.2.1, Зорилт 2, ЗГУАХ-ийн 2.79 дэх заалт	Зарим их, дээд сургуулийг Дархан-Уул, Орхон, Багануур, Сэлэнгэ аймагт нүүлгэн шилжүүлж, ажлыг эхлүүлэх	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100.0	-	БСШУСЯ
10.11	ЗГУАХ-ийн 3.2.23 дахь заалт	Ерөнхий боловсролын сургууль, дотуур байрны хүртээмж, орчин нөхцөлийг сайжруулан хүүхдийн ая тухтай сурч, хүмүүжих орчинг бүрдүүлэх	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100.0	-	БСШУСЯ
10.12	ЗГУАХ-ийн 3.2.2 дахь заалт	Сургууль, цэцэрлэгийн 80 хувиас дээш гүйцэтгэлтэй дутуу барилгын санхүүжилтийг шийдвэрлэж, ашиглалтад оруулах	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100.0	-	БСШУСЯ

Зорилт 11. Соёл, урлаг, спортын салбарыг төрөөс дэмжиж, үндэсний бахархал, эх оронч сэтгэлгээг хөгжүүлнэ.						
11.1	ЗГУАХ-ийн 3.2.46 дахь заалт	Үндэсний бахархал, эх оронч сэтгэлгээг хөгжүүлэхэд чиглэсэн түүхийн сэдэвтэй кино, бүтээл туурвихад төрөөс дэмжлэг үзүүлэх	Түүхэн сэдэвт уран бүтээл туурвих ажлын явц, хувиар	100	0.2 Улсын төсөв	БСШУСЯ
11.2	ЗГУАХ-ийн 3.2.44 дэх заалт, "Төрөөс баримтлах соёлын бодлого"-ын 4.2.1 дэх заалт	Соёл, урлагаар дамжуулан хүүхдийг багаас нь үндэсний соёлын мэдрэмж, мэдлэг, хүмүүжилтэй болгох	Хүүхдэд зориулсан уран бүтээлийн тоо	5	0.2 Улсын төсөв	БСШУСЯ
11.3	ЗГУАХ-ийн 3.2.56 дахь заалт	Нийтийн биеийн тамир, спорт, чийрэгжүүлэлтийн үйлчилгээг сайжруулахад төрөөс дэмжлэг үзүүлэх	Магадлан итгэмжлэгдэх байгууллагын тоо	30	0.08 Улсын төсөв	БСШУСЯ
11.4	ЗГУАХ-ийн 3.2.45 дахь заалт	Төрийн болон орон нутгийн өмчийн соёл урлагийн зориулалттай театр, соёлын төв, музей, номын сангуудын барилгын нөхцөл байдлыг үнэлж, үйл ажиллагаа явуулах нөхцөлийг сайжруулах	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100.0	-	БСШУСЯ
Зорилт 12. Эрдэм шинжилгээ, судалгаа, инновацийг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлж, шинжлэх ухаан, харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарын үйл ажиллагааг өргөжүүлнэ.						
12.1	МУТХҮБ-2030-ын 2.2.3-ын Зорилт 5, ЗГУАХ-ийн 3.2.19 дэх заалт	Эрдэм шинжилгээ, судалгааг хөгжүүлэхэд төрөөс дэмжлэг үзүүлэх	Эрдэм шинжилгээ, судалгааны зардлын ДНБ-д эзлэх хувь	0.12	23.3 Улсын төсөв	БСШУСЯ



12.2	МУТХҮБ-2030-ын 2.2.3, зорилт 5, ЗГҮАХ-ийн 3.2.19 дэх заалт	Инновацийг хөгжүүлэхэд төрөөс дэмжлэг үзүүлэх	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувилар	100.0	10	БСШУСЯ
12.3	МУТХҮБ-2030-ын 2.2.3-ын Зорилт 5, ЗГҮАХ-ийн 3.2.36 дахь заалт	Шинжлэх ухааны парк байгуулах эрх зүйн орчинг бүрдүүлэх	Шинээр болон шинэчлэн боловсруулах эрх зүйн баримт бичгийн тоо	5	-	БСШУСЯ
12.4	МУТХҮБ-2030-ын 2.1.5, Зорилт 7, ЗГҮАХ-ийн 5.1.17 дахь заалт	Төрөөс цахим хэлбэрээр хүргэх үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх	Цахим хэлбэрт шилжүүлэх үйлчилгээний нэр төрөл	35	2.0 Улсын төсөв	Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар / цаашид "ХХМТГ" гэх/
12.5	МУТХҮБ-2030-ын 2.1.5, Зорилт 7, ЗГҮАХ-ийн 3.3.7 дахь заалт	Мэдээлэл харилцаа холбооны технологийн чиглэлийн энтерпренёр бэлтгэх	Бэлтгэл ажлын явц, хувилар	100	0.7 Улсын төсөв	ХХМТГ
12.6	МУТХҮБ-2030-ын 2.1.5, Зорилт 7, ЗГҮАХ-ийн 5.2.8 дахь заалт	Төрийн байгууллагуудад цахим албан хэрэг солилцооны нэгдсэн мэдээллийн системийг нэвтрүүлэх	Цахим систем нэвтрүүлэх ажлын явц, хувилар	80.0	3.0 Улсын төсөв	ХХМТГ
<p>Зорилт 13. Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлж, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна.</p>						

13.1	<p>МУТХҮБ-2030-ын 2.2.2, Зорилт 1, 3, Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого /цаашид "ТЭМТББ" гэх/-ын 2.4.1.5-7, 2.4.2.4, ЗГУАХ-ийн 3.1.2 дахь заалт</p>	<p>Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх хүрээнд урьдчилан сэргийлэх үзлэгийг өргөтгөх, байгууллагын чадавхыг сайжруулах</p>	<p>Эрүүл мэндийн байгууллагуудад эрсдэлийн нөөцийн сан бүрдүүлэх ажлын явц, хувиар</p>	30.0	6.2 Улсын төсөв	Эрүүл мэндийн яам / цаашид "ЭМЯ" гэх/, ОБЕГ
13.2	<p>МУТХҮБ-2030-ын 2.2.2, Зорилт 4, ЗГУАХ-ийн 3.1.6 дахь заалт</p>	<p>Зонхилон тохиолдох халдварт өвчний оношилгоо эмчилгээний чадавхыг сайжруулах</p>	<p>10 000 хүн амд ногдох сурьээгийн тохиолдлын түвшин Жирэмсэн эмэгтэчүүдийн дундаж тэмбүүгийн тархалт, хувиар 10 000 хүн амд ногдох вирус гепатитын тохиолдлын түвшин</p>	<p>14.4-өөс ихгүй 2.5-аас ихгүй 2.9-өөс ихгүй</p>	5.3 Улсын төсөв 1.5 Гадаад эх үүсвэр	ЭМЯ
13.3	<p>МУТХҮБ-2030-ын 2.2.2, Зорилт 2, ТЭМТББ-ын 2.4.1.8, ЗГУАХ-ийн 3.1.7, 3.1.8 дахь заалт</p>	<p>Эх, хүүхдэд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж, эндэгдлийг бууруулах</p>	<p>100 000 амьд төрөлтөд ногдох эхийн эндэгдлийн түвшин, промиль 1000 амьд төрөлтөд ногдох нялхсын эндэгдлийн түвшин, промиль 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин, промиль</p>	<p>27 13.7 16.1</p>	-	ЭМЯ



13.4	ТЭМТББ-ын 2.4.6.5-6, ЗГУАХ- ийн 3.1.9 дэх заалт	Нотолгоонд суурилсан эм зүйн тусламж, үйлчилгээг өргөжүүлэх, эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх	Шинээр бэлтгэгдэх клиникийн эм зүйчийн тоо	25	0.58 Улсын төсөв	ЭМЯ
13.5	ТЭМТББ-ын 2.4.5.1, ЗГУАХ-ийн 3.1.4, 3.1.10 дахь заалт	Эрүүл мэндийн байгууллагын тоног төхөөрөмжийг шинэчлэн сайжруулах	Эмийн аюулгүй байдлын мэдээллийн цахим жорыг нэвтрүүлэх эрүүл мэндийн байгууллагын тоо	100	4.7 Улсын төсөв	ЭМЯ
13.6	МУТХҮБ-2030-ын 2.2.2, зорилт 1, ЗГУАХ-ийн 3.1.2 дахь заалт	Иргэн бүрийг жилд 1 удаа эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах бодлогыг үе шаттай хэрэгжүүлж эхлүүлэх	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100.0	-	ЭМЯ
13.7	ЗГУАХ-ийн 3.1.1 дэх заалт	Осол гэмтэл, түлэнхийн тусламж, үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлж төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хэрэгжүүлэх	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100.0	-	ЭМЯ
<p>Зорилт 14. Хүн амын хөгжил, нийгмийн хамгаалал, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлого боловсруулж, эрх зүйн орчинг сайжруулна.</p>						

14.1	МУТХҮБ-2030-ын 2.2, Төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлогын 4.3.3, 4.3.6, ЗГҮАХ-ийн 3.4.2, 3.3.18 дахь заалт	Гэр бүл, өсвөр үе залуучуудын хөгжлийг дэмжиж, нийгмийн хамгааллын эрх зүйн орчинг боловсронгуй болгох	Шинээр болон шинэчлэн боловсруулах эрх зүйн баримт бичгийн тоо	2	-	ХНХЯ
			Шинээр боловсруулах хөтөлбөрийн тоо	2	-	
14.2	МУТХҮБ-2030-ын 2.2, ЗГҮАХ-ийн 3.3.28, 3.4.4 дэх заалт	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн амьдралд хэвийн оролцох боломжийг бүрдүүлэх	Шинээр байгуулах хөгжлийн төвийн тоо	6	0.6 Гадаад эх үүсвэр	ХНХЯ
			Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийн төвийн барилгын ажлын явц, хувиар	70.0	20.0 Гадаад эх үүсвэр	
14.3	МУТХҮБ-2030-ын 2.2, ЗГҮАХ-ийн 3.3.28, 3.4.4 дэх заалт	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдтэй ажиллах нарийн мэргэжлийн багш нарыг бэлдэх, тэдний цалин, хөлс, урамшууллыг нэмэгдүүлэх, сургалтын тусгай тоног төхөөрөмж, автобустай болгох, эцэг, эхийн асаргааны зардал болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тэтгэмжийг нэмэгдүүлэх	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100	-	ХНХЯ

14.4	МУТХУБ-2030-ын 2.2.1, Зорилт 3, ЗГҮАХ-ийн 3.3.21 дэх заалт	Даатгуулагчийн тусламж, үйлчилгээний чанарыг сайжруулах зорилгоор эрүүл мэндийн даатгалын бие даасан байгууллагыг хөгжүүлэх эрх зүйн орчинг боловсронгуй болгох	Шинэчлэн боловсруулах эрх зүйн баримт бичгийн тоо	1	-	ХНХЯ
14.5	МУТХУБ-2030-ын 2.2.1, Зорилт 2, ЗГҮАХ-ийн 3.3.7 дахь заалт	Монгол Улсын иргэн гадаадад, гадаадын иргэн Монгол Улсад хөдөлмөр эрхлэх, тэдний эрхийг хамгаалах эрх зүйн орчинг бүрдүүлэх	Шинэчлэн боловсруулах эрх зүйн баримт бичгийн тоо	1	-	ХНХЯ
14.6	МУТХУБ-2030-ын 2.2.3, Зорилт 3, ЗГҮАХ-ийн 3.2.9 дэх заалт	Мэргэжлийн боловсрол, сургалтын эрх зүйн орчинг боловсронгуй болгох	Шинэчлэн боловсруулах эрх зүйн баримт бичиг	1	-	ХНХЯ
			Боловсруулах журмын тоо	3 хүртэл		
			Судалгааны ажил тоо	1		
14.7	МУТХУБ-2030-ын 2.2.1, Зорилт 2, ЗГҮАХ-ийн 3.3.11 дэх заалт	Багш нарын цалин хөлсний ангилал, зэрэглэлийг боловсронгуй болгох бодлого хэрэгжүүлэх	Ангилал, зэрэглэлийг шинэчлэх албан тушаал	-	-	ХНХЯ, БШУСЯ

14.8	МУТХҮБ-2030-ын 2.2.1, Зорилт 1, ЭЗСХ-ийн 1.1.8 дахь заалт	Бичил аж ахуйн нэгж, иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг зээлийн бодлогоор дэмжих	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас зээл авах бичил аж ахуйн нэгж, иргэдийн тоо Шинээр бий болох ажлын байрны тоо	7000	13.0 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	ХНХЯ
				10000		
14.9	МУТХҮБ-2030-ын 2.2.1, зорилт 2, ЗГҮАХ-ийн 3.4.10 дахь заалт	Их, дээд сургууль, МСҮТ төгсөгчдөд өөрт бий болгосон үр чадвартаа түшиглэн ажлын байр, орлоготой болох гарааны бизнесийн дэмжлэг үзүүлэх, тоног төхөөрөмж лизингээр олгох хөтөлбөр хэрэгжүүлэх	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувимар	100.0	-	ХНХЯ
14.10	МУТХҮБ-2030-ын 2.2.1, зорилт 3, ЗГҮАХ-ийн 3.3.21 дэх заалт	Эрүүл мэндийн даатгалын бие даасан, даатгуулагч төвтэй, орчин үеийн менежменттэй тогтолцоог бий болгох, эрүүл мэндийн даатгалын иргэдэд хүрэх үр өгөөжийг нэмэгдүүлэх арга хэмжээг үе шаттай авч хэрэгжүүлэх	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувимар	100.0	-	ХНХЯ, ЭМЯ
14.11	ЗГҮАХ-ийн 3.3.17 дахь заалт	Нийгмийн даатгалын хамрах үйлчилгээг өргөжүүлсэн тэтгэврийн даатгалын тогтолцоог шинэчлэх эрх зүйн орчинг бий болгох	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувимар	100.0	-	ХНХЯ

14.12	ЗГҮАХ-ийн 3.4 дэх заалт	Ахмад настны тухай, Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн хэрэгжилтийг хангах арга хэмжээг авч ажиллах	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100.0	-	ХНХЯ
14.13	ЗГҮАХ-ийн 3.3.11 дэх заалт	Багш, эмч, эмнэлгийн ажилтны ажлын ачаалал, үр чадвар, мэргэшил, ажлын үр дүн, онцлог, ажилласан жил, гаргасан амжилт зэргээс хамаарсан цалин, хөлс, урамшуулал олгодог шинэ тогтолцоог бий болгох	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100.0	-	ХНХЯ, БСШУСЯ, ЭМЯ
14.14	ЗГҮАХ-ийн 3.3.11 дэх заалт	Төрийн албан хаагчид /эмч, багш/-ын цалин болон ахмад настны тэтгэвэр, тэтгэмжийг 2018 оноос үе шаттай нэмэгдүүлэх	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100.0	-	ХНХЯ, БСШУСЯ, ЭМЯ
14.15	ЗГҮАХ-ийн 3.3.12, 3.3.14 дэх заалт	"Хүүхдийн мөнгө", "Цалинтай ээж" хөтөлбөрт шаардагдах зардлыг төсвийн давсан орлогоос үе шаттай нэмэгдүүлэх	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100.0	-	ХНХЯ
14.16	МУТХҮБ-2030-ын 2.2.1, Зорилт 2	Ажлын байр нэмэгдүүлэхэд шаардагдах санхүүжилтийн асуудлыг 2018 оноос үе шаттай хуваарилах, иргэдийн эрүүл мэнд, боловсролын үйлчилгээг нэмэгдүүлэхэд чиглэсэн зорилтуудыг хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүгийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100.0	-	ХНХЯ

ТАВ. ЗАСАГЛАЛ, ЭРХ ЗҮЙН ШИНЭЧЛЭЛ, ГАДААД БОДЛОГО, БАТЛАН ХАМГААЛАХ САЛБАРЫН БОДЛОГО

Зорилт 15. Эрх зүйн салбарын шинэчлэлийг үргэлжлүүлж, мөнгө угаах, хүний наймаа, хар тамхины болон цахим гэмт хэрэг зэрэг шинэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлж, бууруулна.

15.1	ЗГУАХ-ийн 5.4.11, дэх заалт	Архивын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах, төрийн архивуудад хадгалагдаж байгаа баримтыг цахим хэлбэрт шилжүүлж, мэдээллийн сан бүрдүүлэх	Шинэчлэн боловсруулах эрх зүйн баримт бичгийн тоо	1	-	ХЗДХЯ, Архивын ерөнхий газар
15.2	ЗГУАХ-ийн 5.3.6, 5.3.7, 5.3.10 дахь заалт	Гэрч, хоширогчийг хамгаалах, нийгмийн зорилтот бүлгийн иргэдэд үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа үзүүлэх эрх зүйн орчинг боловсронгуй болгох	Нийт баримтыг цахим хэлбэрт шилжүүлэх ажлын явц, хувиар	22.0	-	ХЗДХЯ
15.3	ЗГУАХ-ийн 5.4.10 дахь заалт	Шүүхээр шийдвэрлүүлж байгаа хэрэг, маргаан болон хүн амын төвлөрлийг харгалзан шийдвэр гүйцэтгэх чадавхыг бэхжүүлэх	Шинэчлэх техник, тоног төхөөрөмжийн хувь	25.0	-	ХЗДХЯ
			Шинээр болон шинэчлэн боловсруулах эрх зүйн баримт бичгийн тоо	2	-	ХЗДХЯ
			Шинээр байгуулах шийдвэр гүйцэтгэх хэсгийн тоо	3	5.1 Улсын төсөв	ХЗДХЯ



15.4	ЗГҮАХ-ийн 5.4.10 дахь заалт	Ялтныг ажлын байраар хангах бодлого хэрэгжүүлэх	Ялтныг ажлын байраар хангах хувь	60.0		ХЗДХЯ
			Нэмэгдүүлэх үйлдвэрийн тоо	4	6.2 Улсын төсөв	
			Тухайн жилд олсон орлогоос гэм хорыг барагдуулах хэмжээ, хувиар	100		
15.5	ЗГҮАХ-ийн 5.4.4 дэх заалт	Мөнгө угаах, хүний наймаа, хар тамхины болон цахим гэмт хэргийг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх	Шинээр болон шинэчлэн боловсруулах эрх зүйн баримт бичгийн тоо	3	15.2 Улсын төсөв	ХЗДХЯ
			Хэрэгжүүлэх хөтөлбөрийн тоо	1		
15.6	Цагдаагийн байгууллагын хөржлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний 6.2 дахь заалт	Гэмт хэрэг, ослоос урьдчилан сэргийлэх зорилгоор орон нутгийн замын хяналтыг сайжруулах	Барих хяналтын цэгийн тоо	27	2.1 Улсын төсөв	ХЗДХЯ
15.7	ЗГҮАХ-ийн 5.2.9, 5.3.12 дахь заалт	Иргэний болон хуулийн этгээдийн архивын цаасан баримтыг цахимжуулах	Цахимжуулах ажлын явц, хувиар	100	-	ХЗДХЯ, Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газар
			Цахим банкны үйлчилгээ нэвтрүүлэх ажлын явц, хувиар	100	2.8 Улсын төсөв	

15.8	ЗГУАХ-ийн 5.4.13 дахь заалт	Хилийн заставын цахилгаан, дулаан хангамжийг сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрээр шинэчлэх	Нарны эх үүсвэрээр хангах хилийн заставын тоо	30	9.0 Улсын төсөв	ХЗДХЯ
15.9	ЗГУАХ-ийн 5.4.7 дахь заалт	Шүүхийн шинжилгээний чанарыг дээшлүүлж, шинжилгээний бүртгэл, мэдээлэл, лавлагааны нэгдсэн тогтолцоо бий болгох	Байгуулах лабораторийн тоо	3	-	ХЗДХЯ
15.10	ЗГУАХ-ийн 5.3.7 дахь заалт	Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх	Боловсруулах хөтөлбөрийн тоо	1	-	ХЗДХЯ
15.11	ШШБайгууллагын Стратеги зорилтыг хэрэгжүүлэх ҮАТ-ний 3.3 дахь заалт	Орчин үеийн эрүүл ахуйн стандартад нийцсэн Шүүх эмнэлгийн байрыг шинээр байгуулах	Барих байрны тоо	2	6.5 Улсын төсөв	ХЗДХЯ
15.12	ЗГУАХ-ийн 5.3.12 дахь заалт	Төрийн байгууллагаас гадаадын иргэдэд үзүүлэх үйлчилгээг цахимжуулах	Цахимжуулах ажлын явц, хувимар	20.0	-	ХЗДХЯ
15.13	ЗГУАХХАХТ-ний 5.4.4.3 дахь заалт	Цагдаагийн байгууллагын дотоод холбоо, мэдээллийн нэгдсэн систем болон бэлэн бус торгуулийн системийг цагдаагийн үйл ажиллагаанд бүрэн нэвтрүүлж, цагдаагийн байгууллагын түргэн шуурхай ажиллах, иргэдэд чирэгдэлгүй үйлчлэх нөхцөлийг бүрдүүлэх	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувимар	100	10.0 Улсын төсөв	ХЗДХЯ, ЦЕГ



Зорилт 16. Төрийн өмчийн талаар баримтлах бодлогыг шинэчилж, худалдан авах ажиллагаа, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах, стандарт хэмжил зүй, мэргэжлийн хяналтын байгууллагын үйл ажиллагааг сайжруулна.						
16.1	МУТХҮБ-2030-ын 2.4, Зорилт 1-2, ЗГҮАХ-ийн 1.1.4, 5.2.1 дэх заалт	Төрийн өмчийн үр ашгийг сайжруулах, Төрийн өмчийг хувьчлах үндсэн чиглэл, бодлогыг шинэчлэх	Баримт бичгийг боловсруулж, батлуулах ажлын явц, хувиар	100	-	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар /цаашид «ТӨБЗГ» гэх/
16.2	МУТХҮБ-2030-ын 2.4, Зорилт 1-2, ЗГҮАХ-ийн 5.2.2 дахь заалт	Худалдан авах ажиллагааны тогтолцоог боловсронгуй болгож, цахим хэлбэрээр зохион байгуулах	Нийт худалдан авалтад цахим худалдан авалтын эзлэх хувь	100	0.18 Улсын төсөв	ТӨБЗГ
16.3	МУТХҮБ-2030-ын 2.4, Зорилт 1-2, ЗГҮАХ-ийн 2.12 дахь заалт	“Зах зээлийн өрсөлдөөнийг дэмжих”, “Хэрэглэгчийн эрхийг хамгаалах” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх	Хөтөлбөрийн хэрэгжилт, хувиар	30-аас багагүй	-	Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар
16.4	МУТХҮБ-2030-ын 2.1.1-2.1.3, 2.1.5, 2.1.7, ЗГҮАХ-ийн 2.7 дахь заалт	Монгол Улсын үндэсний стандартыг шинээр боловсруулж, мөрдүүлэх	Шинээр боловсруулж, батлуулах стандартын тоо	25	-	Стандарт, хэмжил зүйн газар /цаашид “СХЗГ” гэх/
16.5	МУТХҮБ-ын 2.1.7, Зорилт 1, ЗГҮАХ-ийн 2.8, 2.23 дахь заалт	Орон нутгийн мэргэжлийн хяналтын байгууллагын лабораторийн нөхцөлийг сайжруулах	Лабораторийн барилгын ажлын явц, хувиар	100	0.82 Улсын төсөв	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар
16.6	МУТХҮБ-2030-ын 2.4, Зорилт 1, ЗГҮАХ-ын 5.1 дэх заалт	Төрийн аудитын стандартыг боловсруулж, эрх зүйн орчинг боловсронгуй болгох	Шинээр болон шинэчлэн боловсруулах эрх зүйн баримт бичгийн тоо	2	-	Үндэсний аудитын газар, СХЗГ

Зорилт 17. Хөрш орнуудад хийх худалдааг өргөжүүлэх бодлого хэрэгжүүлж, хилийн чанадад амьдарч буй монгол иргэдийн эрх ашгийг хамгаалах тогтолцоог сайжруулна.

17.1	<p>Гадаад бодлогын үзэл баримтлал /цаашид "ГБҮБ" гэх/-ын 3.21.6, ЗГҮАХ-ийн 5.6.5, 5.6.7, ЭЗСХ-ийн 2.1.2 дахь заалт</p>	<p>Хөрш орнуудтай хийх худалдааг өргөжүүлэх зорилгоор хил дамнансан эдийн засгийн хамтын ажиллагааны чөлөөт бүс байгуулах ажлыг эрчимжүүлэх</p>	<p>Замын-Үүд-Эрээний чөлөөт бүс байгуулах ажлын явц, хувиар</p>	<p>50.0</p>	<p>0.2 Улсын төсөв</p>	<p>Шадар сайдын ажлын алба, Гадаад харилцааны яам /цаашид "ГХЯ" гэх/</p>
17.2	<p>МУТХҮБ-2030-ын 2.1.7, Зорилт 1, ЗГҮАХ-ийн 5.6.5, ЭЗСХ-ийн 1.1.6 дахь заалт</p>	<p>Монголын бараа, бүтээгдэхүүнийг таатай нөхцөлөөр экспортлох боломжийг бүрдүүлэх, тарифын болон хязгаарлалтыг бууруулах</p>	<p>Яриа хэлэлцээр хийх орны тоо</p>	<p>3-аас багатай</p>	<p>-</p>	<p>ГХЯ</p>
17.3	<p>ГБҮБ-ын 2.14.1, ЗГҮАХ-ийн 5.6.2, ЭЗСХ-ийн 2.1.2 дахь заалт</p>	<p>Монгол Улс, ОХУ, БНХАУ-ын "Эдийн засгийн коридор байгуулах хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх хүрээнд Хөрөнгө оруулалтын зураг төслийн төв байгуулах</p>	<p>Төв байгуулах ажлын явц, хувиар</p>	<p>100</p>	<p>-</p>	<p>ГХЯ</p>
17.4	<p>ГБҮБ-ын 6.27.5, ЗГҮАХ-ийн 5.3.12 дахь заалт</p>	<p>Хилийн чанадад байгаа монгол иргэдийн эрх ашгийг хамгаалах, тэдэнд үзүүлэх үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах</p>	<p>Цахим үйлчилгээний нэр төрөл, тоогоор</p>	<p>20-иос багатай</p>	<p>-</p>	<p>ГХЯ</p>

Зорилт 18. Энхийг сахиулах, улс орны бүтээн байгуулалтыг дэмжих хүрээнд батлан хамгаалах салбарын чадавхыг бэхжүүлнэ.

18.1	МУТХҮБ-2030-ын 2.4, ЗГҮАХ-ийн 5.5.2, 5.5.10 дахь заалт	Улс орны бүтээн байгуулалт, хүмүүнлэгийн ажиллагаанд оролцох үүрэг бүхий цэргийн ангиудыг бэхжүүлэх	Бүтээн байгуулалтад оролцох Зэвсэгт хүчний оролцооны түвшин, хувиар	33.0	4.5 Улсын төсөв 1.8 Зэвсэгт хүчний хөгжлийн сан /цаашид "ЗХХС" гэх/	Батлан хамгаалах яам /цаашид "БХЯ" гэх/			
18.2	ЗГҮАХ-ийн 5.5.3, Зэвсэгт хүчний байгуулалтыг 2020 он хүртэл хөгжүүлэх хөтөлбөр /цаашид "ЗХБХХ гэх"/-ийн 4.1.5, 4.3.3 дахь заалт	Монгол Улсын агаарын хил, орон зайн хяналтын системийг сайжруулж, онц чухал объект, цэргийн бүлэглэлийг агаараас халхлах боломжийг нэмэгдүүлэх	Агаарын хил, орон зайн хяналт тавих чадавхын өсөлт, хувиар	10.0	0.6 ЗХХС	БХЯ			
18.3	ЗГҮАХ-ийн 5.5.5, ЗХБХХ-ийн 4.2.4 дэх заалт	НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд инженерийн ротыг бэлтгэж, оролцуулах	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100	-	БХЯ			
18.4	МУТХҮБ-2030-ын 2.4, ЗГҮАХ-ийн 5.5.2 дахь заалт	Цэргийн сургалт, бэлтгэлийн тогтолцоо, материаллаг баазыг бэхжүүлэх	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100.0	-	БХЯ			
18.5	МУТХҮБ-2030-ын 2.4, ЗГҮАХ-ийн 5.5.6 дахь заалт	Материаллаг нөөцийн тодорхой хувийг шинэчлэх, хадгалах нөхцөлийг бүрдүүлэх, «Цувраажилт» төслийг хэрэгжүүлэх, нөөцийг оновчтой шилжүүлэн байршуулах	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100.0	-	БХЯ			



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2017 оны 04 дүгээр
сарын 21-ний өдөр

Дугаар 82

Улаанбаатар
хот

Зарим хүмүүсийг шүүхийн шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1, Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1, 18.2, 18.3.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Өндөр насны тэтгэвэр авах насанд хүрсэн Дамдинжавын Солонгыг Сүхбаатар дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн, Пүрэвийн Баттулгыг Дархан-Уул аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн албан тушаалаас, шүүгчийн албан тушаалаас чөлөөлөгдөх хүсэлтээ бичгээр гаргасан Дамцагдоржийн Бүрнээг Булган аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн албан тушаалаас тус тус чөлөөлсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**ЦАХИАГИЙН
ЭЛБЭГДОРЖ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2017 оны 04 дүгээр
сарын 21-ний өдөр

Дугаар 83

Улаанбаатар
хот

Зарим шүүхийн шүүгч, Ерөнхий шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1, Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Өөр албан тушаалд томилогдох болсонтой холбогдуулан Ганбатын Ариунаа, Төмөрбаатарын Ганчимэг нарыг Багануур дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн, Данжаадын Уранчимэгийг Багахангай, Налайх дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн, Лхагвасүрэнгийн Нарангэрэлийг Баянхонгор аймаг дахь сум



дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн, Галбадрахын Солонгыг Өмнөговь аймгийн Ханбогд сум дахь сум дундын шүүхийн шүүгчийн, Төмөрбаатарын Болормааг Хэнтий аймгийн Бор-Өндөр сум дахь сум дундын шүүхийн шүүгч, Ерөнхий шүүгчийн, Базаррагчаагийн Түмэнцэцэгийг Дорнод аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн, Бүүвэйбаатарын Мөнхбаярыг Сэлэнгэ аймгийн Сайхан сум дахь сум дундын шүүхийн шүүгчийн, Батжаргалын Дэлгэрцэцэгийг Дундговь аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн албан тушаалаас тус тус чөлөөлсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**ЦАХИАГИЙН
ЭЛБЭГДОРЖ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2017 оны 04 дүгээр
сарын 21-ний өдөр

Дугаар 84

Улаанбаатар
хот

Зарим хүмүүсийг анхан шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд шилжүүлэн томилох тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1, Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.5 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Багануур дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Ганбатын Ариунааг Баянгол дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн, Багануур дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Төмөрбаатарын Ганчимэг, Багахангай, Налайх дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Данжаадын Уранчимэг нарыг Сүхбаатар дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн, Хэнтий аймгийн Бор-Өндөр сум дахь сум дундын шүүхийн шүүгч, Ерөнхий шүүгч Төмөрбаатарын Болормааг Баянзүрх дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн, Өмнөговь аймгийн Ханбогд сум дахь сум дундын шүүхийн шүүгч Галбадрахын Солонгыг Багануур дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн, Баянхонгор аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Лхагвасүрэнгийн Нарангэрэлийг Багахангай, Налайх дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн, Дорнод аймаг дахь сум дундын Иргэний хэргийн



анхан шатны шүүхийн шүүгч Базаррагчаагийн Түмэнцэцэгийг Сүхбаатар дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн, Сэлэнгэ аймгийн Сайхан сум дахь сум дундын шүүхийн шүүгч Бүүвэйбаатарын Мөнхбаярыг Хан-Уул дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн, Дундговь аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Батжаргалын Дэлгэрцэцэгийг Орхон аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд тус тус шилжүүлэн томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**ЦАХИАГИЙН
ЭЛБЭГДОРЖ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2017 оны 05 дугаар
сарын 09-ний өдөр

Дугаар 88

Улаанбаатар
хот

Элчин сайдыг эгүүлэн татах, тохоон томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Монгол Улсаас Бүгд Найрамдах Азербайжан Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Бадамдоржийн Батхишигийг эгүүлэн татаж, Бүгд Найрамдах Азербайжан Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Равдангийн Болдыг томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**ЦАХИАГИЙН
ЭЛБЭГДОРЖ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2017 оны 05 дугаар
сарын 09-ний өдөр

Дугаар 89

Улаанбаатар
хот

Элчин сайдыг эгүүлэн татах, тохоон томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14



дүгээр зүйлийн 3, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Монгол Улсаас Бүгд Найрамдах Македони Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Лхамсүрэнгийн Дүгэржавыг эгүүлэн татаж, Бүгд Найрамдах Македони Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Дашжамцын Батсайханыг томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**ЦАХИАГИЙН
ЭЛБЭГДОРЖ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2017 оны 05 дугаар
сарын 09-ний өдөр

Дугаар 90

Улаанбаатар
хот

**Элчин сайдыг эгүүлэн татах,
тохоон томилох тухай**

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Монгол Улсаас Бүгд Найрамдах Албани Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Шижээхүүгийн Одонбаатарыг эгүүлэн татаж, Бүгд Найрамдах Албани Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Цэрэндоржийн Жамбалдоржийг томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**ЦАХИАГИЙН
ЭЛБЭГДОРЖ**

ЗАЛРУУЛГА

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2017 оны 23 дугаарт нийтлэгдсэн “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль”-ийн 31.4 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийн 3.1, 3.2, 3.3, 3.4, 3.5, 3.6 дахь заалтын дугаарыг 4.1, 4.2, 4.3, 4.4, 4.5, 4.6 гэж залруулан уншина уу.

Хаяг:

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакц,
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот
И-мэйл: turiin_medeel@parliament.mn

Утас: 262420

Хэвлэлийн хуудас: 2.75

Индекс: 200003